

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Мягмар гараг  
Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-10
<hr/>	
<i>1.Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулга</i>	4-6
<i>2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүний халдашигүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/</i>	6-8
<i>3.Улсын Их Хурдын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай/</i>	8-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
11 дүгээр сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 07 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Э.Болормаа, Б.Батбаатар, Т.Доржханд,  
Л.Оюун-Эрдэнэ, Л.Гантөмөр, Э.Одбаяр, Ц.Туваан;  
Чөлөөтэй: О.Алтангэрэл, Ө.Шижир, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар.

**Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор  
байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулга**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг, Хяналт шалгалтын газрын зөвлөх Ж.Монголжингоо, референт Х.Хэрлэн нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулгыг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав

**Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатараас ирүүлсэн саналыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг оруулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/-ийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав*

**Гурав.Улсын Их Хурлын тогтоолын төсөл** /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 24 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 31 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
15 цаг 07 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Дашзэвэгийн Амарбаясгалан,  
Жудгийн Баярмаа, Нямтайширын  
Номтойбаяр, Ням-Осорын Учрал,  
Лувсанцэрэнгийн Энх-Амгалан,  
Жадамбын Бат-Эрдэнэ, Сархадын  
Зулхар, Бөхчулууны Пүрэвдорж,  
Гончигдоржийн Уянгахушиг,  
Баярмагнайн Баярбаатар, Одсүрэнгийн  
Номинчимэг, Цэндсүрэнгийн Сандаг-  
Очир, Одонгийн Цогтгэрэл гэсэн гишүүд  
ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байна.

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулга.

2.“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны

бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.“Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэгдүгээр асуудал. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан ажлын хэсгийн танилцуулга.**

Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 8 сарын 21-ний өдрийн 01 тогтоолоор батлагдсан.

Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч О.Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүний микрофонд урья.

**О.Номинчимэг:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.5 дахь хэсэгт Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална гэж заасныг үндэслэн энэ тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан.

Энэ ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг

миний бие, Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа, Пүрэвжавын Сайнзориг, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан байгаа.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан Нийтийн сонсгол зохион байгуулах журам гээд нийтдээ ийм 4 салангид баримт бичгээр бол зохион байгуулж ирсэн.

Үүнийг цэгцэлж Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-нд баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол энэ бол ерөнхийдөө бид нар ерөнхий хяналтын сонсголыг ярьж байгаа. Хяналт шалгалтын түр хороо байгуулдаг сонсгол биш хяналтын сонсголыг зохион байгуулах энэ зарим харилцааг нарийвчилсан зохицуулж, ингээд хуульчилж Дэгийн хууль дээрээ бол оруулсан байгаа.

Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар бүлэг бүхэлдээ Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах журам гээд нарийвчилсан харилцаануудыг зохицуулсан байна. Үүнд,

119 дүгээр зүйлд Улсын Их Хурлын хяналтын сонсгол явуулах талаар хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх талаар 120 дугаар зүйл Сонсгол зохион байгуулах харьяаллын талаар, 121 дүгээр зүйл Сонсголын бэлтгэл ажлыг хангах талаар, 123, 124 дүгээр зүйл Сонсголд оролцогч түүний эрх, үүргийн талаар, 125 дугаар зүйл Сонсгол даргалагчийн

эрх, үүрэг, 126, 127 дугаар зүйл Сонсголыг танхимаар болон цахимаар явуулах журам, 126 дугаар зүйл Сонсголын тайлан, тэмдэглэл боловсруулж, олон нийтэд түгээх талаар, 129-133 дугаар зүйлд нэр дэвшигчийн сонсгол байгуулах журмыг бол нарийвчилж дэгийн хуулиар зохицуулсан.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын хяналтын сонсголыг дээр дурдсан хуулийн зохицуулалтын хүрээнд зохион байгуулах боломжтой гэж ажлын хэсгээс дүгнэсэн.

Тэгээд нарийвчилсан журам батлан гаргах тохиолдолд хуулийн зохицуулалтыг давхардуулан журамд тусгах нөхцөл байгаа. Тэгээд Хууль тогтоомжийн тухай хуулиараа хуульд зохицуулсан зүйлийг журамд зохицуулж болохгүй гэсэн ийм зохицуулалттай.

Ийм учраас ерөнхий журмыг бол дэгийн хуулиараа нарийвчлан зохицуулсан учраас энэ тусад нь одоо хүлээгдэж байгаа ганц, хоёр асуудлыг зохицуулахын тулд журмын төслийг тусад нь боловсруулах шаардлагагүй гэж ажлын хэсэг бол дүгнэсэн байгаа.

Тэгээд 2024-28 оны парламентын бүрэн эрхийн хугацаанд бас холбогдох журмын тоог цөөлж, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг журмаар биш хуульд тусгаж байх стратегийг энэ Улсын Их Хурал баримталж байгаа.

Тэгэхээр энэ стратегийн хүрээнд ч гэсэн тусад нь нарийвчилсан буюу ихэнх зүйл нь хууль дээр тусчихсан асуудлыг бол энэ журамд тусгах шаардлагагүй гэж ажлын хэсэг дүгнэсэн.

Мөн цаашид хууль хэрэглээний хувьд ойлгомжтой болох үүднээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хяналтын сонсголыг зохион байгуулахтай холбоотой зарим шаардлагатай зохицуулалтуудыг нэмж

гаргах, нэмж тусгах саналыг бол ажлын хэсгээс гаргасан.

Тухайлбал, тус хуулийн 121 дүгээр зүйлийн 121.6-д шинжээчийг томилохдоо ажлын хэсгийн саналыг үндэслээд Байнгын хороо тогтоол гаргахаар зохицуулсан байдаг. Тэгтэл нөгөө талаараа сонсгол дээр ажлын хэсэг байгуулагдаагүй тохиолдолд шинжээч томилох хүсэлт гаргах субъект нь хэн байх юм, ямар эрх, үүрэгтэй оролцох юм гэдэг нарийвчилсан зохицуулалтыг бас тодорхой болгох шаардлагатай байна гэж үзэж байна.

Мөн түүнчлэн сонсголыг явуулах бүтэц бол бид нар энэ хууль, Дэгийн хуулиараа ажлын хэсэг, эсвэл сонсгол даргалагч гэдэг хүнийг тусад нь томилоод байгаа. Бид олон улсын зөв жишгийг харах юм бол ер нь бүх сонсгол энэ ажлын хэсэг гэхээсээ тусдаа ийм бүтэц гаргана гэхээсээ илүү ерөөсөө Байнгын хороо, дэд хороон дээрээ тулгуурлаад энэ хороо өөрөө бодлого гаргадаг, хяналт шалгалт хийдэг функцийнхээ, чиг үүргийнхээ хүрээнд сонсголыг ч гэсэн энэ хүрээндээ хийж байх нь зүйтэй, тусад нь даргалагч байхгүй, дэд хороо болон Байнгын хороо өөрсдөө энийг зохион байгуулж байх нь зүйтэй гэсэн энэ саналууд бас гарсан байгаа. Ингэж байж бидний зорьж байгаа Байнгын хороо маань үйл ажиллагаа нь илүү мэргэжсэн, гаргаж байгаа шийдвэрүүд, санал дүгнэлтүүд, Байнгын хороо, дэд хорооноос гаргах шийдвэр уялдаа холбоотой байх ийм ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас ийм бас өөрчлөлтийг хийх саналыг дэвшүүлж байна.

Мөн 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсэг, 126.6 дугаар зүйлийн 126.5 дахь хэсгийг бол энэ нарийвчилсан журам гаргана гэсэн энэ асуудлуудыг заалтуудыг бол өөрчилнө.

Үүнээс гадна нэлээн техникийн шинж чанартай буюу хугацаа тоолох, нэр тодорхойлолтыг илүү боловсронгуй

болгох асуудлуудыг бол манай Тамгын газрын зөвлөхүүд, хяналт шалгалтын зөвлөхүүдээс бас боловсруулаад ийм 3 хуудас бас санал гаргасан байгаа. Тэгэхээр Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ асуудлуудыг цэгцэлж, нэгмөсөн хуульдаа өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн ажлын хэсгийн дүгнэлтийг та бүхэнд танилцууллаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн ахлагч Номинчимэг гишүүний танилцуулсан танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Алга байна.

Санал хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд сонслоо тийм үү тээ? Асуулт асуух, санал асуух гишүүд алга байна. Дараагийн асуудалдаа орёе. Танилцуулга сонсож дуулаа.

15.16 цаг

## **2. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол.**

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Монгол Ардын намын бүлгээс санал ирсэн байгаа. Саналыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Дашиэвэгийн Амарбаясгалан танаа санал хүргүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1

дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооны Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарыг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг оруулах саналыг хүргүүлж байна. Бүлгийн дарга Л.Мөнхбаатар гэсэн байна.

Мөнхбаатар гишүүний хүргүүлсэн саналтай холбогдуулан, хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуух асуулт байвал нэрсээ өгнө үү.

Баярбаатар даргаар, Баярбаатар гишүүнээр, Баярбаатар гишүүнээр тасалъя. Баярбаатар гишүүн.

**Б.Баярбаатар:** Би, энэ Халдашгүй байдлын дэд хороо чинь өөрөө бас чухал л даа. Энэ чинь бас нэлээн хэдэн удаа бүрэлдэхүүнд нь өөрчлөлт ороод өнгөрсөн хурлаар чинь нөгөө даргын томилсон уу, томилоогүй билүү дарга?

**Ж.Бат-Эрдэнэ:** Томилоогүй.

**Б.Баярбаатар:** Томилох гэж байгаад больчихсон тээ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Больчихсон тийм.

**Б.Баярбаатар:** Тэгээд өнгөрсөн хуралдааныг чинь би нөгөө бараг Ганбаатар гишүүний чинь даргаар нь томилох гэж байна гэж ойлгоод байсан. Тэгвэл өнөөдөр ингээд буцаагаад татчихаж байгаа юм байна гэж ойлгох уу, зөв үү?

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбаатар гишүүн даргаар нь томилогдохоос татгалзсан. Тийм болохоор бүрэлдэхүүнээ эхлээд өөрчилж байгаа юм. Эхлээд бүрэлдэхүүнээ өөрчлөөд Улсын Их Хурлаа оруулаад, тэгээд буцаж хүрч ирээд хэдүүлээ эндээ дахиад

дараагийн шатанд даргаа томилох юм байгаа шүү.

**Б.Баярбаатар:** Ойлголоо.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тийм. Санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Алга байна.

Улсын Их Хурлын, Жамбалын Ганбаатарыг Улсын Их Хурлын гишүүнийг Халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг тус дэд хорооны гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Ингээд “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэж дууслаа.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүн танилцуулна.

15.23 цаг

**Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт, дараагийн асуудал оръё, төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтад төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй байх бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварыг холбогдох шийдвэрийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр байгаа, байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт зааснаар хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, энэ хуулийн 14.1.2, 14.1.3-д зааснаас бусад тайлан мэдээлэл, илтгэл сонсох, төсөв, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах болон хяналт шалгалтын бусад асуудлыг Улсын Их

Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгаж хэрэгжүүлэх хяналт шалгалтын талаар Байнгын хороодоос холбогдох саналыг авах, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тусгайлан санал ирээгүй байна.

Байнгын хорооноос ирүүлсэн санал болон хяналт шалгалтын бусад асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулагдах нэр дэвшигчдийн хяналтын сонсголыг Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусган боловсруулсан болно гэж.

Ингээд тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварыг авсан. Тэгээд яах вэ яг процесс яаж явсныг нь мэдэхгүй байна. Яагаад гэвэл энд нөгөө Байнгын хороодоос, уг нь бол Байнгын хороо, дэд хороодоос хийх төлөвлөгөөт хянан шалгалтыг саналыг нь авч байгаа тээ? Миний хувьд бол энэ Төрийн байгуулалтын байнгын хорооноос гадна, Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаг, мөн Хүний эрхийн дэд хороонд харьяалагддаг.

Хүний эрхийн дэд хороо бол яг энэ хяналт шалгалттай холбоотой хэд хэдэн ажлыг бас өөрсдийн төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа юм. Хууль зүйн байнгын хороон дээр яг энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудал дээр ямар хяналт шалгалтын үйл ажиллагаа

явуулах вэ гэдэг асуудал гишүүдийн дунд л лав ямар ч байсан Байнгын хороон дээр яригдаагүй.

Ингээд харахаар хяналт шалгалтын бусад асуудал гэдэг юмаар орж ирээд, яг тайлан, мэдээлэл хэлэлцэх, эсвэл хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт бас гишүүд олон уг нь санал өгч байгаа.

Тэгэхээр энэ асуудлууд тусгагдаагүй байхаар процессын хувьд бид нар энийг яаж явсан юм бол гэдгийг нэгдүгээрт дуулчихмаар байна.

Хоёрдугаарт, нэмэлт энэ саналыг оруулахын тулд ямар шатад, яаж гаргах вэ? Яагаад гэвэл иргэдээс ирж байгаа маш их санал, хүсэлт, өргөдлийн дагуу хууль зүйн бодлоготой холбоотой, ялангуяа иргэний хэргийн шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийн хууль тогтоомжийн биелэлт, гүйцэтгэл ямар байна, энэтэй холбоотой асуудлууд байгаа учраас үүнийг бас энэ шалгалтын цаглаварт оруулья гээд бид бас ажиллаж байгаа юм.

Тэгэхээр энэтэй холбоотой л процесс энэ саналууд яаж явж тусгагдаж байна, яагаад ингээд зарим юмнууд тусгагдаагүй юм бол гэдгийг асууж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сая миний танилцуулгад орсон Аюулгүй байдлын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2 саналаа өгөөгүй юм байна. Тусгасан саналгүй.

Хууль зүйн байнгын хорооноос ирсэн санал энэ Төрийн байгуулалтын байнгын хороонд дарга Ж.Бат-Эрдэнэ танаа гээд 10 сарын 25-ны өдөр Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатарын албан бичигтэй ийм юу ирсэн байна шүү, санал ирсэн байна шүү.

Энэ дээр цаглаварт тусгах хяналт шалгалт гээд 5, 5 саналыг ирүүлсэн байна. Энэ дээр 5, 5 дээр нь санал ирсэн

юм уу? Эд нар чинь байхгүй байгаад байгаа юм байна шүү дээ тийм үү? Тайлан сонсох гэсэн юм, аан за за нэг л санал ирсэн юм байна.

Энэ дэгээрээ энэ чинь одоо санал авч болох билүү айн? Зөвхөн Байнгын хорооноос авч, санал авна гэж байгаа тээ?

Энэ Дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйл Байнгын хороо, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих гэж байна.

Тэгэхээр энэ Байнгын хороо, дэд хорооноосоо л санал авах юм байна шүү дээ. Тийм, Тэгэхээр одоо бол бид нар санал гаргах бололцоогүй.

Хүний эрхийн дэд хороон дээр санал ирсэн юм уу? Ирээгүй байна гэж байгаа юм.

Нөхөж бол болно шүү дээ тийм үү? Нөхөж болно, заавал нэг удаа гэсэн юм байхгүй шүү дээ. Тийм. Үгүй, нөхөж бол болно шүү дээ.

Асуулт асууж, гишүүд асуулт асууж дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд үг хэлж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалт, санал, дүгнэлтийг хэнээр унших вэ?

Номинчимэг гишүүн санал, дүгнэлтийг уншъя.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.31 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР